



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 04 сарын 23 өдөр

Дугаар 33

Есөнбулаг сум

"Эрүүл хүүхэд Алтайн ирээдүй" дэд
хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын "Ж" заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. "Эрүүл хүүхэд Алтайн ирээдүй" дэд хөтөлбөрийг нэгдүгээр, хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. "Эрүүл хүүхэд Алтайн ирээдүй" аймгийн дэд хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн төсөвт тусган батлуулж, биелэлтийн явц, үр дүнг жил бүрийн эцэст аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д даалгасугай.

ДАРГА



Т.ГАНЗОРИГ

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны
04 дүгээр сарын 23-ны өдрийн 23 дугаар
тогтоолын 1-р хавсралт



"ЭРҮҮЛ ХҮҮХЭД – АЛТАЙН ИРЭЭДҮЙ" ДЭД ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөр боловсруулах үндэслэл

Манай аймгийн 57441 хүн амын 22459 буюу 39.09 хувийг 0-19 хүртэлх насны хүүхэд эзэлж байна. Үүнээс нэг хүртэлх насны 1253, тав хүртэлх насны 5053 хүүхэд байна.

Сүүлийн 5 жилд тус аймагт 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 23.1 промилль байгаа нь улсын эндэгдлийн түвшнээс 1.2 пунктээр илүү байна¹.

Сүүлийн хоёр жилийн байдлаар нялхсын эндэгдэл 1000 амьд төрөлтөд 16.2, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 20.4 байгаа нь улсын дундаж түвшнээс доогуур болж, Мянганы хөгжлийн зорилтыг биелүүлсэн хэдий ч, хүүхдийн өвчлөл, эндэгдэл тогтвортой буурахгүй байна.

5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 86.1 хувийг нялхсын эндэгдэл, нялхсын эндэгдлийн 66.1 хувийг нярайн эндэгдэл, нярайн эндэгдлийн 77.9 хувийг нярайн эрт үеийн эндэгдэл эзэлж байгаагийн гол шалтгаан нь эхийн эрүүл мэндийн байдлаас шалтгаалсан дутуу болон бага жинтэй нярай төрж байгаатай холбоотой байна.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 55.3 хувийг төрөх тойрны эмгэг, 17.5 хувийг осол гэмтэл, 13.5 хувийг төрөлхийн хөгжлийн гажиг, 10.8 хувийг амьсгалын тогтолцооны өвчнүүд эзэлж байна. Эдгээрээс осол гэмтэл, төрөлхийг гажиг улсын дунджаас 4 хувиар их байна. 0-19 насны хүүхдийн осол гэмтлийн шалтгаант нас баралтын 7 тохиолдлын 5 буюу 71.4 хувийг 5-14 насны хүүхэд эзэлж байна. 2016 онд түлэгдэлтийн 22 тохиолдол бүртгэгдсний 95.6 хувь нь тав хүртэлх насны хүүхэд байна. Иймээс хүүхдийн өсч торниж байгаа орчны аюулгүй байдлыг хангах, хүүхдэд тавих анхаарал, халамжийг сайжруулах талаар эцэг, эх, асран хамгаалагчийн мэдлэг хангалтгүй, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Өсвөр насны хүүхдийн эрүүл мэндийн талаар хийгдсэн судалгаа байхгүй, эрүүл мэндийн боловсрол дутмаг, тэдэнд чиглэсэн тусламж үйлчилгээний хүртээмж хангалтгүй байна. Охидын төрөлт 5 жилийн дунджаар 4 хувь байгаагийн 71.0 хувийг хөдөө сумын охид эзэлж байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт

2.1 Хөтөлбөрийн зорилго:

Эцэг, эх, асран хамгаалагчид, иргэд, хүүхдэд нас насны онцлогт тохирсон эрүүл мэндийн боловсрол олгох, гэр бүл, аж ахуйн нэгж, байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай, хүртээмжтэй үзүүлэх замаар хүүхдийн өвчлөл, эндэгдлийг бууруулахад оршино.

2.2 Хөтөлбөрийн зорилт

Зорилт 1. Эцэг, эх, асран хамгаалагчид, хүүхдүүдэд нас насны онцлогт тохирсон эрүүл мэндийн боловсрол олгох,

Зорилт 2. Хүүхэд эрүүл өсөн бойжих ээлтэй орчныг бүрдүүлэхэд гэр бүл, байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах,

Зорилт 3. Хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах

2.3 Хөтөлбөр хэрэгжих хугацаа

Хөтөлбөрийг 2017-2020 онд хэрэгжүүлнэ.

2.4 Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

Эцэг, эх, асран хамгаалагчид, хүүхдүүдэд нас насны онцлогт тохирсон эрүүл мэндийн боловсрол олгох зорилтын хүрээнд:

1. Эхийн хэвлийд ураг бүрэлдсэн цагаас 2 нас хүртэлх амьдралын эхний 1000 хоногийн хооллолт, асаргаа, сувилгааны талаар эцэг, эх, асран хамгаалагчдад мэдлэг олгох
2. Иргэдэд жирэмсний эрт хяналтын ач холбогдлыг таниулах, жирэмснийг эхний 3 сарын хугацаанд илрүүлж, хяналтыг сайжруулах
3. 6 сар хүртэл дагнан хөхөөр хооллохын ач холбогдлыг ойлгуулах, дэмжих
4. Эцэг, эх, асран хамгаалагчдад бага насны хүүхдийг осол гэмтлээс сэргийлэх талаар сурталчлах
5. Хүүхдийн нас насанд тохируулан харьцах, тэднийг хүндлэн ойлгох, хүүхдээ өөртөө итгэлтэй байлгах чадварт сургах
6. Өсвөр насныханд жирэмслэлт, БЗДХ, хорт зуршлаас сэргийлэх, хооллолтын зөв дадал эзэмшүүлэх

Хүүхэд эрүүл өсөн бойжих ээлтэй орчныг бүрдүүлэхэд гэр бүл, байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах зорилтын хүрээнд:

1. Олон эмэгтэй ажиллагчтай байгууллага, аж ахуйн нэгжид хүүхэд хөхүүлэх өрөө гаргах зэрэг эх, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэлтийг дэмжиж "Эх, Хүүхдэд ээлтэй байгууллага" шалгаруулах
2. Сургууль, цэцэрлэгийн тогооч нарын ур чадварыг сайжруулах
3. Сургуулийн орчинд шүдэнд халтай хүнсний бүтээгдэхүүн худалдаалах, шарсан, хайрсан болон түргэн хоолыг үйлдвэрлэхгүй байх нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах
4. Сургууль, цэцэрлэгүүдийг эмчтэй болгож, ажлын байрны тодорхойлолтыг хамтран шинэчлэн боловсруулах
5. Эрүүл мэндийн хичээлийн олимпиадыг зохион байгуулах
6. Эрүүл мэндийн хичээлийн үнэлгээ хийх

Хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд:

1. D амин дэм дутлын судалгаа хийж, үр дүнг тооцох
2. 5 хүртэлх насны хүүхдийг D амин дэмээр хангах
3. 5 хүртэлх насны хүүхдийн өсөлтийг зөв үнэлж, өсөлт хоцрогдолтой холбоотой суурь өвчлөлийг бууруулах

4. 6 сараас 2 нас хүртэлх насны хүүхдийг олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлээр хангах
5. Өсвөр насныханд урьдчилан сэргийлэх үзлэг хийж, зонхилон тохиолдох өвчлөлийн судалгаа гарган эмчлэх эрүүлжүүлэх
6. Нярайн бодисын солилцооны эрт илрүүлэг хийх

Гурав. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

3.1 Хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн Засаг даргын зөвлөлөөр хэлэлцэж, улмаар аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд тайлагнана.

3.2 Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнд аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэс хяналт үнэлгээг хийнэ.

Дөрөв. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин				
		Суурь үзүүлэлт	2018	2019	2020	2021
1	Жирэмсний эхний 3 сартайд хяналтанд авсан хувь	86.3	87.0	88.0	90.0	90.0
2	2 хүртэлх насны хүүхдийн хооллолтын зөвлөгөө авсан эцэг, эх, асран хамгаалагчийн тоо	0	5000	5300	5500	6000
3	6 сар хүртэл эхийн сүүгээр дагнан хоололтын хувь	65%	67.0	70.0	75.0	80%
4	Зөв дадал эзэмших сургалтанд хамрагдсан өсвөр насны хүүхдийн тоо	0	250	500	750	1000
5	“Эх хүүхдэд ээлтэй байгууллага”-ын тоо	0	3	5	8	10
6	Сургалтанд хамрагдсан тогооч нарын тоо	0	15	0	0	0
7	Нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан байгууллагын тоо	0	10	20	30	50
8	Д аминдэмээр хангагдсан 5 хүртэлх насны хүүхдийн эзлэх хувь	0	0	20.0	30.0	30.0
9	Д аминдэм дутлын судалгаанд хамрагдсан хүүхдийн хувь	0	30.0	0	0	0
10	Нярайн бодисын солилцооны эрт илрүүлэгт хамрагдсан хүүхдийн хувь	0	60	0	0	0

11	ОНБТХ-оор хангагдсан 2 хүртэлх насны хүүхдийн хувь	50.0	65.0	75.0	85.0	100.0
12	Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан өсвөр насны хүүхдийн хувь	0	30.0	50.	75.0	100.0
13	Эмчлэн эрүүлжсэн өсвөр насны хүүхдийн хувь	0	10.0	15.0	25.0	30.0
14	Осол гэмтлээс шалтгаалсан 5-14 насны хүүхдийн эндэгдлийн түвшин, 1000 хүүхдэд	0.5	0.45	0.4	0.4	0.35

---oOo---

11	ОНБТХ-оор хангагдсан 2 хүртэлх насны хүүхдийн хувь	50.0	65.0	75.0	85.0	100.0
12	Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан өсвөр насны хүүхдийн хувь	0	30.0	50.	75.0	100.0
13	Эмчлэн эрүүлжсэн өсвөр насны хүүхдийн хувь	0	10.0	15.0	25.0	30.0
14	Осол гэмтлээс шалтгаалсан 5-14 насны хүүхдийн эндэгдлийн түвшин, 1000 хүүхдэд	0.5	0.45	0.4	0.4	0.35

---oOo---

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны
 04 дүгээр сарын 23 ны өдрийн 23 дугаар
 тогтоолын 2-р хавсралт

"ЭРҮҮЛ ХҮҮХЭД-АЛТАЙН ИРЭЭДҮЙ" ДЭД ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжүүлэх байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хугацаа	Санхүүжилт \сая. төг\
Зорилт 1. Эцэг, эх, асран хамгаалагчид, хүүхдүүдэд нас насны онцлогт тохирсон эрүүл мэндийн боловсрол олгох							
1	Эхийн хэвлийд ураг бүрэлдсэн цагаас 2 нас хүртэлх амьдралын эхний 1000 хоногийн хооллолт, асаргаа, сувилгааны талаар эцэг, эх, асран хамгаалагчдад мэдлэг олгох	Жирэмсэн ээжүүдэд хооллолтын зөвлөгөө өгөх сургалт зохион байгуулах	Тухайн жил хяналтанд орсон жирэмсэн ээжүүдийн 30-аас доошгүй хувь	ЭМГ	НЭ, СӨЭМТ	2018-2020	4.0 УТ
		Эцэг, эх, асран хамгаалагчдад жирэмсэн үеийн хооллолтын зөвлөгөө өгөх сургалт зохион байгуулах	Хүн амын 30-аас доошгүй хувь	ЭМГ	СӨЭМТ	2018-2020	4.0 УТ
		Жирэмсэн ээжүүдэд хооллолтын талаар ганцаарчилсан зөвлөгөө өгөх	Тухайн жил хяналтанд орсон жирэмсэн ээжүүдийн 70-аас доошгүй хувь	ЭМГ	НЭ, СӨЭМТ	2018-2020	2,0 УТ
2	Иргэдэд жирэмсний эрт хяналтын ач холбогдлыг таниулах,	Иргэдэд жирэмсний эрт хяналтын ач холбогдлын талаар сургалт зохион байгуулах	Хүн амын 30-аас доошгүй хувь	ЭМГ	СӨЭМТ	2018-2020	4.0 УТ

	жирэмснийг эхний 3 сарын хугацаанд илрүүлж, хяналтыг сайжруулах	талаар сургалт зохион байгуулах					
		Сум, өрхийн ЭМТ-үүдийн жирэмсний эрт хяналтын байдалд үнэлгээ хийх	Тухайн жил хяналтанд орсон жирэмсэн эхийн 87-оос доошгүй хувь	ЭМГ	СӨЭМТ	2018-2020	2,0 УТ
3	6 сар хүртэл дагнан хөхөөр хооллохын ач холбогдлыг ойлгуулах, дэмжих	Жирэмсэн ээжүүдэд дагнан хөхөөр хооллолтын талаар сургалт зохион байгуулна	Тухайн жил хяналтанд орсон жирэмсэн ээжүүдийн 70-аас доошгүй хувь	ЭМГ	НЭ, СӨЭМТ	2018-2020	2,0 УТ
		Олон эмэгтэйчүүд ажилладаг байгууллагын удирдлагуудад нөлөөллийн ажил зохион байгуулах	Нөлөөллийн ажил зохион байгуулсан байгууллагын тоо	ЭМГ	СӨЭМТ, ДЗМОУБ	2018-2020	4,8 ДЗөн
		6 сар хүртэлх хүүхэдтэй эцэг, эх, асран хамгаалагчдад сургалт зохион байгуулах	Сургалтанд хамрагдсан хүний тоо	ЭМГ	СӨЭМТ	2018-2020	4,0 ДЗөн
4	Эцэг, эх, асран хамгаалагчдад бага насны хүүхдийг осол	5 хүртэлх насны хүүхэдтэй эцэг, эх, асран хамгаалагчдад сургалт зохион байгуулах	Сургалтанд хамрагдсан хүний тоо	ЭМГ	СӨЭМТ	2018-2020	6,0 ДЗөн

	гэмтлээс сэргийлэх талаар сурталчилах	“Ногоон гэрэл, цагаан шугам” тэмцээнийг хамтран зохион байгуулах	Тэмцээнд оролцсон хүүхдийн тоо, оролцсон байгууллагын тоо	ЭМГ	БСУГ, ЦХ, СӨЭМТ	2018-2020	2,0 УТ
		Хүүхдийн осол гэмтлээс сэргийлэх ээлтэй орчин бүрдүүлэхийг сурталчилсан сарын аян зохион байгуулах	Аянд орлцон байгууллага, хүний тоо	ЭМГ	БСУГ, ЦХ, СӨЭМТ	2018-2020	2,0 УТ
5	Хүүхдийн нас насанд тохируулан харьцах, тэднийг хүндлэн ойлгох, хүүхдээ өөртөө итгэлтэй байлгах чадварт сургах	Бага насны хүүхэдтэй эцэг, эх, асран хамгаалагчдад хүүхэд хамгааллын ганцаарчилсан зөвлөгөө өгөх	5 хүртэлх насны хүүхэдтэй эцэг, эх, асран хамгаалагчдын 40-өөс доошгүй хувь	ЭМГ	СӨЭМТ	2018-2020	1,0 УТ
		6-11 хүртэл насны хүүхэд, тэдгээрийн эцэг эх, асран хамгаалагч нарын дунд амны хөндийн эрүүл мэнд, гар угаах дадал хосолсон, “Хүрэхүйн” тухай сургалтууд хийх	Сургалтын чиглэл-3 Хамрагдалт 70-аас доошгүй хувь	ЭМГ	НТБТ СӨЭМТ	2018-2020	4,0 УТ
		Өсвөр насны хүүхэдтэй эцэг, эх, асран хамгаалагчдад өсвөр үеийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлын талаар сургалт зохион байгуулах	Сургалтанд хамрагдсан хүний тоо, өсвөр үеийн тулгамдсан асуудлын талаар эрүүл	ЭМГ	БСУГ, НТБТ, НЭ, СӨЭМТ	2018-2020	2,0 УТ

			мэндээр эрсдэлтэй хүүхдийн эзлэх хувь				
6	Өсвөр насныханд жирэмслэлт, БЗДХ, хорт зуршлаас сэргийлэх, хооллолтын зөв дадал эзэмшүүлэх	Өсвөр үеийнхэнд зөв дадлын талаар сургалт зохион байгуулах	Өсвөр насныхны 70-аас доошгүй хувь	ЭМГ	БСУГ ,НТБТ НЭ, СӨЭМТ	2018-2020	2,0 УТ
		Сургуулийн эмчээр дамжуулан “Үе тэнгийн сургагч”-дыг чадавхжуулах	“Үе тэнгийн сургагч”-дын 90-ээс доошгүй хувь	БСУГ	НЭ, СӨЭМТ	2018-2020	-
		“Үе тэнгийн сургагч”-аар дамжуулан өсвөр үеийнхэнд сурталчилгаа зохион байгуулах	Өсвөр насныхны 70-аас доошгүй хувь	ЭМГ	БСУГ,НЭ, СӨЭМТ	2018-2020	2,0 УТ
		Аймгийн төвийн сургуулиудын дунд, ахлах ангийн сурагчдын дунд АХА, дэвжээ тэмцээн зохион байгуулах	Хамрагдсан хүүхдийн тоо	ЭМГ	БСУГ, НЭ	2018-2020	2,0 УТ
Хүүхэд эрүүл өсөн бойжих ээлтэй орчныг бүрдүүлэхэд гэр бүл, байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах зорилтын хүрээнд:							
1	Олон эмэгтэй ажиллагчтай байгууллага, аж ахуйн нэгжид хүүхэд хөхүүлэх өрөө гаргах	Хүүхэд хөхүүлэх өрөө гаргах зэрэг эх, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэлтийн нөлөөллийн ажил зохион байгуулах	Нөлөөллийн ажил зохион байгуулсан байгууллагын тоо	ЭМГ	СӨЭМТ, ДЗМОУБ	2018-2020	2,0 ДЗөн

	зэрэг эх, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэлтийг дэмжиж "Эх, Хүүхдэд ээлтэй байгууллага" шалгаруулах	"Эх, Хүүхдэд ээлтэй байгууллага" шалгаруулах журам боловсруулан нэгжүүдэд хүргүүлэх	Журам боловсруулсан байна	ЭМГ	СӨЭМТ	2018-2020	-
		"Эх, Хүүхдэд ээлтэй байгууллага" шалгаруулах	Жил бүр 5-аас доошгүй байгууллага	ЭМГ	Аймаг, сумын ЗДТГ, СӨЭМТ	2018-2020	4.0 ОНХС
2	Сургууль, цэцэрлэгийн тогооч нарын ур чадварыг сайжруулах	Сургууль, цэцэрлэгийн тогооч нарын ур чадварыг сайжруулах сургалт зохион байгуулах	Сургалтанд хамрагдсан хүний тоо	ЭМГ	БСУГ, Тогооч нарын холбоо, СӨЭМТ	2018	3.0 ОНХС
		Хүүхдийн хоолыг сурталчлах ажил зохион байгуулна	Сурталчилгаанд хамрагдсан байгууллагын тоо	ЭМГ	БСУГ, Тогооч нарын холбоо, СӨЭМТ	2019	-
3	Сургуулийн орчинд шүдэнд халтай хүнсний бүтээгдэхүүн худалдаалах, шарсан, хайрсан болон түргэн хоолыг үйлдвэрлэхгүй байх нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах	Нөлөөллийн ажил зохион байгуулах	Нөлөөллийн ажилд хамрагдсан сургуулийн удирдлагын тоо, үйл ажиллагаа зохион байгуулсан сургуулийн тоо	ЭМГ	БСУГ, МХГ, СӨЭМТ	2018-2020	2.0 УТ
4	Сургууль, цэцэрлэгүүдийг эмчтэй болгож, ажлын	Сургууль, цэцэрлэгүүдийг эмчтэй болгох албан хүсэлтийг БСУГ-т хүргүүлэх	Эмчтэй болсон байгууллагын тоо	ЭМГ	БСУГ	2018-2020	-

	байрны тодорхойлолтыг хамтран шинэчлэн боловсруулах	Эмч нарын ажлын байрны тодорхойлолтыг хамтран шинэчлэн боловсруулах	АБТ шинэчлэгдсэн байна	ЭМГ	БСУГ	2018	-
5	Эрүүл мэндийн хичээлийн олимпиадыг зохион байгуулах	5-10, 11-12 дугаар ангийн сурагчид, эрүүл мэндийн хичээлийн багш нарын дунд олимпиад зохион байгуулах	Жил бүр зохион байгуулсан байна, оролцсон багш, сурагчдын тоо	ЭМГ	БСУГ	2018-2020	4.0 ОНХС
6	Эрүүл мэндийн хичээлийн үнэлгээ хийх	Сурагчдын эрүүл мэндийн хичээлээр олж авсан мэдлэгийн үнэлгээ хийх	Мэдлэгийн хувь	ЭМГ	БСУГ	2019-2020	1.0 УТ

Хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд:

1	D амин дэм дутлын судалгаа хийж, үр дүнг тооцох	5 хүртэлх насны хүүхдүүдийн дунд түүврийн аргаар D аминдэм дутлын судалгаа хийх	5 хүртэлх насны хүүхдийн 30-аас доошгүй хувь	ЭМГ	СӨЭМТ	2018	52.5 ОНХС
		Судалгааны үр дүнг тооцож, нэгжүүдэд зөвлөмж хүргүүлэх	22 нэгжид зөвлөмж хүргүүлнэ	ЭМГ	СӨЭМТ	2018	-
2	5 хүртэлх насны хүүхдийг D амин дэмээр хангах	Жил бүр 5 хүртэлх насны хүүхдийн судалгаа гаргах	Судлагааг жил бүр шинэчлэн гаргана	ЭМГ	СӨЭМТ	2018-2020	-

		Эм ханган нийлүүлэх байгууллагуудаас D аминдэмийн үнийн судалгаа	3-аас доошгүй байгууллагаас судалгаа авна	ЭМГ	СӨЭМТ	2018-2020	-
		Зорилтот бүлгийн 5 хүртэлх насны хүүхдийг D амин дэмээр хангах	5 хүртэлх насны хүүхдийн 30-аас доошгүй хувь	ЭМГ	СӨЭМТ	2019-2020	300.0 ОНХС
3	5 хүртэлх насны хүүхдийн өсөлтийг зөв үнэлж, өсөлт хоцрогдолтой холбоотой суурь өвчлөлийг бууруулах	Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд 5 хүртэлх насны хүүхдийн өсөлтийг зөв үнэлэх сургалт зохион байгуулах	Эмч, эмнэлгийн мэргэжилтний 80-аас доошгүй хувь	ЭМГ	СӨЭМТ	2018-2020	100.0 НҮБ ХС
		Хүүхдийн өсөлтийн үнэлгээнд дэмжлэгт хяналт хийх	22 нэгж байгууллага	ЭМГ	СӨЭМТ	2018-2020	12.0 НҮБ ХС
		Өсөлтийн үнэлгээний сарын мэдээнд дүн шинжилгээ хийх	Улирал тутам дүн шинжилгээ хийж нэгжүүдэд зөвлөмж хүргүүлнэ	ЭМГ	СӨЭМТ	2018-2020	-
4	6 сараас 2 хүртэлх насны хүүхдийг олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлээр хангах	Сар бүр 6 сараас 2 хүртэлх насны хүүхдийн судалгаа хийх	Сар бүр судалгаа шинэчлэгдсэн байна	ЭМГ	СӨЭМТ	2018-2020	-
		6 сараас 2 нас хүртэлх насны хүүхдийг олон	80-аас доошгүй хувь	ЭМГ	СӨЭМТ	2018-2020	100.0 НҮБ ХС

		найрлагат бичил тэжээлийн бэлдмэлээр хангах					
		Олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлийн хэрэглээнд үнэлгээ хийх	22 нэгж байгууллагад үнэлгээ хийнэ	ЭМГ	СӨЭМТ	2018-2020	-
5	Өсвөр насныханд урьдчилан сэргийлэх үзлэг хийж, зонхилон тохиолдох өвчлөлийн судалгаа гарган эмчлэх эрүүлжүүлэх	Өсвөр насныханд зонхилон тохиолдох өвчний урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах /шүд, нүд, чих хамар хоолой, БЗДХ, ШБЗӨ/	Тухайн хичээлийн жилд нийт хүүхдийн 70-аас доошгүй хувь	ЭМГ	БСУГ, СӨЭМТ	2018-2020	2.0 УТ
		Зонхилон тохиолдох өвчний судалгаа гаргах	Судалгаа гарна	ЭМГ	БСУГ	2018-2020	-
		Өсвөр насныханд зонхилон тохиолдох өвчнийг эмчлэн эрүүлжүүлэх	Илэрсэн өвчлөлийн 30-аас доошгүй хувь	ЭМГ	НЭ, СӨЭМТ	2018-2020	4.0 УТ
		Бүтэн болон хагас өнчин хүүхдийн шүдийг эмчлэн эрүүлжүүлэх ажлыг шүдний хувийн эмнэлгүүдтэй нийгмийн хариуцлагын гэрээ байгуулах замаар шийдвэрлэх	Бүтэн болон хагас өнчин хүүхдийн 30-аас доошгүй хувь	ЭМГ	Шүдний хувийн эмнэлгүүд	2018-2020	-
6	Нярайн бодисын солилцооны эрт илрүүлэг хийх	Нярайн бодисын солилцооны эмгэгийг эрт илрүүлэх шинжилгээний сорьц цуглуулах	Төрсөн хүүхдийн 60-аас доошгүй хувь	НЭ	ЭМГ	2018	21.2

	Нярайн бодисын солилцооны эмгэгийг эрт илрүүлэхэд эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах	Эмнэлгийн мэргэжилтэн-20	НЭ	ЭМГ	2018	0.736
	Нярайн бодисын солилцооны эмгэгийг эрт илрүүлэх шинжилгээний дүнг үндэслэн урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээ авах	Шинжилгээний дүнг үндэслэн төлөвлөгөө гарган батлуулсан байна	НЭ	ЭМГ	2018-2020	УТ
Нийт зардал		657.2				
Улсын төсөв		43.0				
Орон нутгийн төсвийн зардал		385.4				
ОУ-ын төсөл, хөтөлбөр		228.8				

∞ ∞ ∞ ∞ ∞ ∞